

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН НИЙТИЙН ТҮЛХҮҮРИЙН ДЭД БҮТЦИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН ЭНХ-АМГАЛАН ОВОГТОЙ БАЛДАНСАМБУУГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1 “Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төвийг байгуулах”							
1.	Арга хэмжээ 1.1 Тоон гарын үсгийн гэрчилгээжүүлэх байгууллагын үйл ажиллагаанд шалгалт хийж, дүгнэлт гаргах	Шалгалт хийсэн байгууллагын тоо	3	3	Хүрсэн түвшин: Тоон гарын үсгийн гэрчилгээжүүлэх байгууллагын үйл ажиллагаанд 2023 оны 12 дугаар сард 3 байгууллагад шалгалт хийж, зөвлөмж хүргүүлсэн. Зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тайлан хүлээн авч ажилласан. 2024 оны ээлжит шалгалтыг зохион байгуулахаар шалгалтын удирдамжийг боловсруулж, Салбарын улсын байцаагчийн 2024 оны 12 дугаар сарын 05-ний өдрийн 16 дугаар тушаалаар Хяналт шалгалтын удирдамжийг батлуулж, хяналт шалгалт хийх хугацааг 2025 оны 01 дүгээр сард зохион байгуулахаар тусгасан.	10 – 12	90
Зорилт 2 “Кибер аюулгүй байдлын чиглэлээр дотоод, гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах”							

2.	Арга хэмжээ 2.1 Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх Нийтийн төвийн үйл ажиллагаанд шаардлагатай программ хангамж, системийг тодорхойлж, донор байгууллагад хүргүүлэх	Боловсруулсан техникийн тодорхойлолтын тоо	-	2	ибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ-т шаардлагатай байгаа аюулгүй байдлын систем, тоног төхөөрөмж худалдан авах төслийн ажлын даалгаварт Дэлхийн банкнаас ирүүлсэн саналыг тусгасан. Ухаалаг Засаг-2 төсөл хэрэгжүүлэх нэгжтэй хамтран тендерийн баримт бичгийг боловсруулсан. Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/71 дүгээр тушаалаар "Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв байгуулах/тоног төхөөрөмж" төслийн ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулан, худалдан авах ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна. Мөн Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага ЖАЙКА-д тоон ул мөр илрүүлэх тусгай зориулалтын программ хангамж авах хүсэлт гарган, шийдвэрлүүлэхээр болсон. Уг ажлын хүрээнд ЖАЙКА-тай хамтран Нийтийн төвийн үйл ажиллагаанд үнэлгээ хийх дотоодын зөвлөх шалгаруулах ажлыг зохион байгуулж, Арвис Системс ХХК-ийг шалгаруулсан. Зөвлөх үйлчилгээний хүрээнд Нийтийн төвийн үйл ажиллагаанд үнэлгээ хийж шаардлагатай систем тоног төхөөрөмжийн жагсаалтыг эхний	01-06	100
----	---	--	---	---	--	-------	-----

					байдлаар боловсруулж, ЖАЙКА-д хүргүүлээд байна.		
2.	Арга хэмжээ 2.2 Ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг гадаад орны байгууллагатай хамтын ажиллагааг эхлүүлнэ.	Хамтын ажиллагаа эхлүүлсэн байгууллагын тоо	1	2	Хүрсэн түвшин: Литва Улсын NRD компани болон Цахим аюулгүй байдлын мэдээлэл, удирдлагын төв /MNCERT/CC/ нарын дэмжлэгтэйгээр Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх Нийтийн төв УТҮГ-ыг 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдөр Олон улсын кибер аюулгүй байдлын байгууллага "FIRST"-д гишүүнээр элсүүлсэн. Япон улсын компьютерын ослын эсрэг багийн зохицуулах төв (JPCERT/CC) болон Монгол Улсын Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв хооронд байгуулах харилцан ойлголцлын санамж бичгийн төслийг боловсруулж, JPCERT/CC болон Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага ЖАЙКА-д хүргүүлэн санал авч, санамж бичигт тусган хариу хүргүүлээд байна.	01-06	100
3	Арга хэмжээ 2.3 Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төвд ажиллах мэргэшсэн боловсон хүчнийг сургаж, бэлтгэх	Сургалтад хамруулсан албан хаагчийн тоо	-	10	Хүрсэн түвшин: 1. Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага "ЖАЙКА"-тай хамтран 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс 02 дугаар сарын 21-ний өдрүүдэд Япон улсын Токио хотноо "Кибер аюулгүй байдлын хүний нөөцийг хөгжүүлэх" сэдэвт сургалтад 2 албан хаагчийг хамруулсан.	07-09	100

					2. АНУ-ын MITRE байгууллагатай хамтран 2024 оны 03 дугаар сарын 27, 28-ны өдрүүдэд зохион байгуулсан "Онц чухал дэд бүтцийг эрэмбэлэх нь-2" сэдэвт сургалтад 4 албан хаагчийг хамруулсан. 3. 2024 оны 06 дугаар сарын 19-ий өдрөөс 06 дугаар сарын 24-ний өдрүүдэд "Кибер аюулгүй байдлын засаглал ба аудит" сэдэвт сургалтад 2 албан хаагчийг хамруулсан.		
Зорилт 3."Нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчлэх, журам, шаардлага боловсруулах"							
1.	Арга хэмжээ 3.1 Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцийн цагийн бүртгэл хөтлөх журмын төслийг боловсруулж, батлуулна.	Батлагдсан журмын тоо	-	1	Хүрсэн түвшин: "Цагийн бүртгэл хөтлөхөд тавигдах шаардлага"-ыг боловсруулж, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн А/69 дүгээр тушаалаар батлуулсан.	01-03	100
2.	Арга хэмжээ 3.2 Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцэд тавигдах шаардлагын төслийг боловсруулж, батлуулна.	Батлагдсан шаардлагын тоо	-	1	Хүрсэн түвшин: "Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцэд тавигдах шаардлага"-ын төслийг боловсруулан, гэрчилгээжүүлэх байгууллагуудаас санал авч байна.	01-03	60
3.	Арга хэмжээ 3.3 Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчлэх төслийн ажлын даалгавар боловсруулна.	Техникийн тодорхойлолтын тоо	-	1	Хүрсэн түвшин: Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчлэх төслийн ажлын даалгаварт Дэлхийн банкнаас ирүүлсэн саналыг тухай бүр тусгасан. Ухаалаг Засаг-2 төсөл хэрэгжүүлэх нэгжтэй хамтран тендерийн баримт бичгийг боловсруулсан. Цахим	04-06	100

					хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/71 дүгээр тушаалаар "Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцийн суурь системийг шинэчлэх" төслийн ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулсан. Үнэлгээний хорооны хуралдаанаар тендерийн баримт бичгийг боловсруулж, 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр нээлттэй тендер зарласан.		
4.	Арга хэмжээ 3.4 Үндэсний нийтийн түлхүүрийн хэрэглээнд хөндлөнгийн байгууллагаар аудит хийлгэх ажлын даалгавар боловсруулж донор байгууллагад хүргүүлнэ.	Боловсруулсан ажлын даалгаврын тоо	-	1	Хүрсэн түвшин: Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцэд хөндлөнгийн аудит хийх төслийн ажлын даалгаварт Дэлхийн банкнаас ирүүлсэн саналыг тухай бүр тусгасан. Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/71 дүгээр тушаалаар "Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцэд хөндлөнгийн аудит хийх" төслийн ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулсан.	04-06	100
Зорилт 4. "Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх, урьдчилсан сэргийлэх чадавхыг бий болгох, энэ чиглэлийн үйл ажиллагаатай төвүүдийн хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах"							
1.	Арга хэмжээ 4.1 Кибер халдлага зөрчлийн дадлага сургуулилт зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	1	Хүрсэн түвшин: 1.Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Зэвсэгт хүчний Жанжин штабын Кибер аюулгүй байдлын цэргийн командлалтай хамтран 2024 оны 01	01-12	100

					дүгээр сарын 12-ноос 13-ны өдрүүдэд Кибер халдлага зөрчилд хариу үзүүлэх "ITASTIC" команд штабын хамтарсан сургуулилтыг Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд зохион байгуулсан. Арга хэмжээнд кибер аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий 7 байгууллагын 80 алба хаагч хамрагдаж, кибер халдлага, зөрчлийн үед хэрхэн хариу арга хэмжээ авах талаар бодит байдлын сургуулилт хийж, гарсан үр дүнд тулгуурлан байгууллага хооронд санал солилцсон. Кибер халдлага зөрчилд хариу үзүүлэх "ITASTIC-2" команд штабын хамтарсан сургуулилтыг 2024 оны 12 дугаар сарын 12-ноос 13-ны өдрүүдэд кибер аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын төлөөллийг оролцуулан зохион байгуулахаар бэлтгэл ханган ажиллаж байна. Мөн Цахим гарын үсэг нээлттэй хэлэлцүүлгийг 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр зохион байгууллаа. Техник технологийн дэд бүтэц хангалтгүй, хуулийн хүрээнд гарсан олон журам хэрэглэгчдийг төөрөгдүүлж байгаа зэрэг асуудлуудлыг шийдвэрлэхээр уг хэлэлцүүлгийг нээлттэйгээр зохион байгуулсан бөгөөд нээлттэй хэлэлцүүлэгт төрийн байгууллага		
--	--	--	--	--	--	--	--

					болон хувийн хэвшлийг төлөөлж 140 албан хаагч оролцсон.		
Зорилт 5. "Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах"							
1.	Арга хэмжээ 5.1 Хууль тогтоомж болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хүрээнд ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох журмын дагуу боловсруулж батлуулах, тайлагнах	ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тоо, ТЖАХ-ийн гүйцэтгэлийн биелэлтийн тоо,	-	ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тоо - 1 ТЖАХ-ийн гүйцэтгэлийн биелэлтийн тоо - 1	Батлагдсан ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийн биелэлтийн тайланг тухай бүр гаргаж ажилласан.	01-12	100
2.	Арга хэмжээ 5.2 Тушаал шийдвэр цаг үеийн болон бусад асуудлаар удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх	Үүрэг даалгаврыг хугацаанд нь гүйцэтгэсэн эсэх	-	Үүрэг даалгаврыг хугацаанд нь гүйцэтгэж, эргэн тайлагнасан байна.	Тушаал шийдвэр цаг үеийн болон бусад асуудлаар удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлсэн	01-12	100
3.	Арга хэмжээ 5.3 Чиг үүргийн дагуу бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гарган, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх	Холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлсэн эсэх	-	Хэрэгжилтээр	Чиг үүргийн дагуу бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гарган, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлсэн	01-12	100
4.	Арга хэмжээ 5.4 Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль	Хууль болон холбогдох журамд	-	Хэрэгжилтээр	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журам, стандартад нийцүүлэн баримт	01-12	100

	болон холбогдох журам, стандартад нийцүүлэн баримт бичгийн төсөл төлөвлөх, архивын нэгж бүрдүүлэх	нийцүүлэн баримт бичгийн төсөл төлөвлөж, архивын нэгж үүсгэсэн эсэх			бичгийн төсөл боловсруулан ажилласан		
5.	Арга хэмжээ 5.5 Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, холбогдох журамд заасны дагуу цохогдсон өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэх	Өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэсэн тоо	-	Хэрэгжилтээр	Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системээр ирсэн 7, байгууллагад албан тоотоор ирүүлсэн 1 өргөдөл гомдлыг тус тус шийдвэрлэн ажилласан.	01-12	100
6.	Арга хэмжээ 5.6 Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг мөрдөх хэрэгжилтийг хангах	Хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдүүлэх Ашиг сонирхлын мэдүүлгийн тоо	-	ХАСХОМэдүүлэг - 1 Ашиг сонирхлын мэдүүлгийн тоо-хэрэгжилтээр	Хуульд заасан хугацаанд Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг мэдүүлсэн.	01-12	100

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Кибер аюулгүй байдлын олон улсын индексийн тайланг боловсруулж Олон	Боловсруулсан тайлангийн тоо	-	1	Кибер аюулгүй байдлын олон улсын индексийн тайланг боловсруулж Олон Улсын Цахилгаан Холбооны Байгууллагад хүргүүлсэн.	07	100

	Улсын Цахилгаан Холбооны Байгууллагад хүргүүлэх				Тус индексийн 2024 оны тайланд дурдсананаар Монгол Улс 56.36 оноотойгоор 194 улсаас 103 дугаарт жагсаж өмнөх үзүүлэлтээс 17 байраар урагшилсан.		
2.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Кибер аюулгүй байдлын үндэсний хэмжээний арга хэмжээн зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	1	Кибер тусгаар тогтнол II форумыг Кибер аюулгүй байдлын зөвлөл, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, MNCERT/СС нар хамтран 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулахад салбар хэлэлцүүлгүүдийн дүгнэлтийг боловсруулж дэмжлэг үзүүлж ажилласан.	11	100
3.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Эцэг эхийн зөвлөлийн 2024 оны жилийн төлөвлөгөөний хүрээнд ЦХХХЯ-ны гэр бүлийн өдөрлөгийг зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	1	ЦХХХЯ-ны албан хаагчид болон тэдгээрийн хүүхдүүдэд зориулсан Гэр бүлийн өдөрлөгийг 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулж, эцэг, эх, хүүхдэд зориулсан сураглтуудыг зохион байгуулж, эх үрсийн баярын бэлэг гардуулах үйл ажиллагааг хамтран зохион байгуулсан.	05	100
4.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4. Кибер аюулгүй байдлын хүний нөөцийг хөгжүүлэх төслийн хүрээнд сургалт зохион байгуулах	Зохион байгуулсан сургалтын тоо	-	2	1.Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА)-аас 2024 оны 02 дугаар сарын 14-нөөс 21-ний өдрүүдэд Япон улсын Токио хотноо зохион байгуулагдсан “Кибер аюулгүй байдлын хүний нөөцийг хөгжүүлэх” сэдэвт сургалтад тус яам болон холбогдох 11 байгууллагын	06-12	100

					албан хаагчийг хамруулах бэлтгэл ажлыг зохион байгуулж, удирдах албан тушаалын нийт 14 албан хаагчийг хамруулсан. 2.“Онц чухал мэдээллийн дэд бүтэц дэх кибер аюулгүй байдал” сэдэвт семинарыг 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулахаар семинарт урих тухай албан тоотыг 86 байгууллагад хүргүүлж, бүртгэлийг хийгээд байна. Мөн семинарын хөтөлбөрийг боловсруулсны дагуу гүйцэтгэгч байгууллага танилцуулга, агуулгыг бэлтгэсэн.		
5.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5. “Цахимд хэвшье” #Digital_First_D1 арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, 21 аймгийн төрийн байгууллагын албан хаагчдад кибер аюулгүй байдлыг сургалт орох	Сургалт зохион байгуулсан аймгийн тоо	-	18	“Цахимд хэвшье” #Digital_First_D1 арга хэмжээний хүрээнд 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн 18 аймгийн нутгийн захиргааны нийт 3161 албан хаагчдад “Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам” болон кибер аюулгүй байдлыг хангах талаар, кибер аюулгүй байдлын байгууллагын дотоод журмыг боловсруулах, хэрэгжилтийг хэрхэн хангаж ажиллах заавар зөвлөгөө өгөх сургалт хийсэн.	03-05	100

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт


Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7

1.	Удирдлагын академийн төрийн албан хаагчийн мэргэшүүлэх сургалтад хамрагдах	Хичээлийн тоо	-	2	Удирдлагын академийн төрийн албан хаагчийн мэргэшүүлэх сургалтад хамрагдаж "Төрийн албаны хүний нөөцийн бодлого, зохион байгуулалт", "Төрийн албаны дипломат ёс горим" хичээлүүдийг судалсан.	09	100
2.	Богино хугацааны сургалтад хамрагдах	Сургалтын тоо	-	2	Япон Улсын Токио хотод 2024 оны 09 дүгээр сарын 23-наас 10 дугаар сарын 03-ны өдрүүдэд Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлагийн зохион байгуулж байгаа "Кибер аюулгүй байдлын Олон улсын хууль, бодлого боловсруулах" сэдэвт сургалтад хамрагдсан. Арабын Нэгдсэн Эмират Улсын Кибер аюулгүй байдлын зөвлөлөөс тус улсын Абу Даби хотод зохион байгуулж байгаа "Квантум кибер аюулгүй байдал" сэдэвт хуралд оролцсон	10 - 11	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

Ахлах мэргэжилтэн

(Албан тушаал)

/Э.Балдансамбуу/

(Нэр, гарын үсэг)

.....

(Огноо)